



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 24 одор



Дугаар 375

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны стратеги, бүтцийн  
өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
- Энэ тушаал гарсантай холбогдуулан “Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018  
оны 11 дүгээр сарын 22-дрийн 215  
дугаар тушаалын хэвсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БУТЦИЙН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

11/8/2003 5919187 0479510

**Нэг. Нийтлэг үндэслэл**

**1.1. Оршил**

Иргэний нисэхийн еренхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бутцийн хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь Иргэний нисэхийг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого, хөтөлбөр, иргэний нисэхийн тухай хууль тогтоомж, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, Монгол Улсын олон улсын иргэний нисэхийн гэрээ, конвенцоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулахад чиглүүлэх, иргэний нисэхийн үйл ажиллагаанд аюулгүй ажиллагааны болон аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалт, агаарын навигацийн болон нисэх буудлын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг хамарсан байгууллагын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлоход оршино.


**1.2. Үндэслэл**

Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, УИХ-ын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн еренхий тогтолцсоны өөрчлөлт, шинчлэлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн боловсруулав.

**1.3. Хууль тогтоомжийн орчин**

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Чикагогийн конвенци болон түүний Хавсралтууд;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Иргэний нисэхийн тухай хууль;
- Агаарын зайл нисэхэд ашиглах тухай хууль;
- Улсын нисэхийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төрийн болон срон нутгийн ёмчийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын “Дотоод аудитын дүрэм батлах тухай” 2015 оны 483 дугаар тогтоол;



- Монгол Улсын Засгийн газрын "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлах тухай" 2011 оны 311 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2015 оны 258 дугаар тогтоолоор батлагдсан Иргэний нисэхийн өрөнхий газрын дүрэм
- Бусад хууль тогтоомж.


#### 1.4. Арга зүй

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоослын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн өрөнхий загвар" болон олон улсын жишиг, байгууллагын өөрчлөлтийн арга зүй, үйл ажиллагааны төлөвлөлт, Иргэний нисэхийн өрөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр боловсруулсан өмнөх туршлага, мэдээлэлд тулгуурлан боловсрууллаа.

#### 1.5. Агентлагийн үүрэг, хариуцлагын өрөнхий хуваарь

##### 1.5.1. Зам, тээврийн хөгжлийн сайдын өмнө хүлээх үүрэг:

- Иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлогыг боловсронгуй болгох санал боловсруулж сайдад танилцуулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлого, шийдвэрийг иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;
- Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулах;
- Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Чиглагийн конвенци, түүний Хавсралтуудад нийцэн аюулгүй ажиллагааны стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, бүртгүүлэх; тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Агентлагийн хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө. үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан нехцэл, үндэслэлээр хугацаанд нь боловсруулж, төсвийн захирагчид оруулах;
- Агаарын навигацийн төлбөртэй үйлчилгээтэй холбогдох асуудлыг зэрхэн шийдэх;
- Иргэний нисэхийн салбарт холбогдох мэдээлэл цуглуулах, бэлтгэх, солилцох, түгээх, түүнчлэн энэ талаар бусад этгээдтэй хамтран ажиллах;
- Иргэний нисэхийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаанд зохицуулан зарцуулах;
- Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын шууд харьяа алба, байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах;
- Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгасан дүгнэлтийг үндэслэн цаашид осол, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагаас шилжүүлсэн бүрэн эрхийт хэрэгжүүлэх;
- Агаарын тээврийг хөгжүүлэхдэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- Бусад улс орнуудтай агаарын харилцааны хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангах;
- Иргэний нисэхийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, боловсон хүчний бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нехцэл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Аюулгүй ажиллагааг хангасан агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэх;
- Нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх;



- Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг биелүүлэх ажлыг эрхэлсэн ажлын хүрээ, салбарын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангах;
- Агентлагийг өдөр тутмын удирдлагаар хангах, хуулиар эрх олгосон бол захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, мэрдүүлэх;
- Агентлагийн төсөв болон иргэний нисэхийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн дагуу захирсан зарцуулах;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудитын үйл ажиллагаагаар хяналт тавих, тайлгах;
- Монгол Улсын иргэний нисэхийн салбарыг Үндэсний хөгжлийн бодлого, олон улсын чиг хандлагатай уялдуулан шинэчлэн хөржүүлэх, инновацийн болон хөгжлийн бодлогыг боловсруулах, түүнд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулах

#### 1.5.2. Хэрэглэгчийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага

Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангасан нислэгийн хедэлгэвний болон нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх үүргийг хэрэглэгчийн өмнө хүлээж, Зам, тээврийн хөгжлийн сайдад эрхэлсэн асуудлаараа мэргэшлийн зөвлөгөө өгч, холбогдох мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлнэ. Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, туслалцаа дэмжлэг үзүүлнэ.


#### 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн ба бусад хэрэглэгчид дор дурдсан хүрээг хамаарна.



Таних тэмдэг:

- үндсэн хэрэглэгч;
- бусад хэрэглэгчид;
- түншлэгч;
- үйлчлүүлэгч, түншлэгч.



Тус байгууллагаас үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Зам, тээврийн хөгжлийн яам, төрийн өмчтэй болон хувийн хэвшлийн агаарын тээврийн компаниуд, агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд байх бөгөөд иргэний нисэхийн салбарын бодлого боловсруулахад Зам, тээврийн хөгжлийн яамыг мэргэжлийн арга зүй, зөвлөгөө, холбогдох мэдээллээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлдэг бол төрийн өмчийн болон хувийн хэвшлийн агаарын тээврийн компаниуд болон агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудад иргэний нисэхийн үнэмлэх, гэрчилгээ авахтай холбогдуулан мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, мөн тус байгууллагын ажилтнуудад Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хууль, иргэний нисэхийн багц дүрмүүдийг дагаж мөрдөхөд нь дэмжлэг туслалцаа үйлчилгээ үзүүлэхээс гадна тэдгээрийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

Тус байгууллагаас үзүүлэх үйлчилгээний шууд бусад хэрэглэгчид нь бусад яам, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллага, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд байх бөгөөд тэдгээр байгууллагуудтай Монгол Улсын хөгжлийн бодлого боловсруулахад иргэний нисэхийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл гаргаж өгөх, мэдээлэл солилцох, хууль тогтоомжийг сахиулан хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

Тус байгууллагаас үзүүлэх үйлчилгээний үндсэн үйлчлүүлэгч нь иргэний нисэхийн багц дүрмийн дагуу гэрчилгээжих агаарын тээврийн компаниуд, иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч, сургалтын, тээвэр зуучийн болон бусад байгууллагууд, мэргэжлийн үнэмлэх зээмшигчид, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ авагч гадаад, дотоодын агаарын тээврийн компаниуд, нисэх буудлаар үйлчлүүлэгч байгууллага, иргэд байна.

### *Хоёр. Иргэний нисэхийн өрөнхий газрын үйл ажиллагааны стратеги*


#### **2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар**

Иргэний нисэхийн өрөнхий газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, теслийн хэрэгжилтийг хангах, нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, агаарын тээврийн хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх, агаарын навигаци болон нисэх буудлуудын үйлчилгээг хангахад бүх талаар дэмжлэг үзүүлэхэд сршино.

#### **2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**

Иргэний нисэхийн өрөнхий газар нь дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

- 2.2.1. нисэхийн аюулгүй ажиллагаа аюулгүй байдлыг хангах;
- 2.2.2. Монгол Улсын иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- 2.2.3. иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, тесэл боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгч, тус салбарыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын бодлого, чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх;
- 2.2.4. агаарын навигацийн болон нисэх буудлуудын үйлчилгээ, дэд бутцийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх;
- 2.2.5. аялал жуулчлал дэмжсэн, иргэдийн нийгмийн хэрэгцээг хангасан эрэлтэд нийцэхүйц, хүртээмжтэй агаарын тээврийг хөгжүүлэхэд чиглэсэн здийн засгийн зохицуулалтыг бий болгох;



- 2.2.6. ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх;
- 2.2.7. иргэний нисэхийн салбарын боловсон хүчин бэлтгэх.

### 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Иргэний нисэхийн салбарт аюулгүй, үр ашигтай, тогтвортой үйлчилгээ үзүүлэх.

### 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилт нь:


- 2.6.1.1. иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- 2.6.1.2. Монгол Улсын иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- 2.6.1.3. агаарын навигацийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
- 2.6.1.4. нисэх буудлуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
- 2.6.1.5. агаарын тээврийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- 2.6.1.6. салбарын хүний нөөцийг төлөвлөх, бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхийг дээшлүүлэх оновчтой тогтолцоог нэвтрүүлж, төрийн захирагааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах;
- 2.6.1.7. хууль тогтоомж, бодлого, хөтөлберийн хэрэгжилтийн явцад дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргах;
- 2.6.1.8. төсвийг тогтоосон журмын дагуу үр ашигтай зарцуулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх;
- 2.6.1.9. Монгол Улсын иргэний нисэхийн салбарыг Үндэсний хөгжлийн бодлого, олон улсын чиг хандлагатай уялдуулан шинэчлэн хөгжүүлэх, инновацийн болон хөгжлийн бодлогыг боловсруулах, түүнд чиглэсэн төсөл, хөтөлберийг хэрэгжүүлэх.

### 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлж, тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, ажилтнуудын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ. Иргэний нисэхийн ерөнхий газрын стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлнэ.

### 2.6. Үйл ажиллагааны зорилт

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны стратегийн дараах зорилтуудыг тодорхойлж байна.



**2.6.2. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:**


- 2.6.2.1. иргэний нисэхийн салбарын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангуулах;
- 2.6.2.2. аюулгүй ажиллагааны удирдлагыг нэвтрүүлэх.

**2.6.3. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:**

- 2.6.3.1. салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлах;
- 2.6.3.2. иргэний нисэхийн хууль тогтоомж боловсруулах, гадаад дотоодын байгууллага, хуулийн этгээд, иргэнтэй байгууллагын зүгээс байгуулах гэрээ, хэлэлцээрийн тесөл боловсруулах, батлуулахад хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, мэргэжлийн арга зүйгээр хангах, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- 2.6.3.3. иргэний нисэхийн багц дүрэм боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах;
- 2.6.3.4. салбарын стандарт, норм, норматив, журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;
- 2.6.3.5. ИНЕГ-аас боловсруулан гаргаж байгаа эрх зүйн баримт бичгийн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэх;
- 2.6.3.6. салбарын хэмжээнд мөрдөж буй хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах арга хэмжээ авч кодификаци хийх;
- 2.6.3.7. иргэний нисэхийн ерөнхий газрын даргын эрхлэх хүрээний асуудлаар гарсан эрх зүйн маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын удирдлагыг итгэмжлэлээр төлөөлөн оролцох, үр дүнг тайлагнах;
- 2.6.3.8. иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлага болон ажилтнуудад эрх зүйн асуудлаар тайлбар зөвлөгөө өгөх, хууль тогтоомж, түүнийг хэрэглэх талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.

**2.6.4. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:**

- 2.6.4.1. агаарын навигацийн үйлчилгээний бодлого, хөтөлбөр, тесөл, стандартын санал боловсруулах, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангуулах;
- 2.6.4.2. олон улсын стандарт, шаардлагад нийцсэн аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хангалтыг зохион байгуулах;
- 2.6.4.3. Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүрх олон улсын өнгөрөлтийн нислэг, дамжин тээвэрлэлтийн нислэгийн хэмжээг өсгөх;
- 2.6.4.4. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж буй дотоод, гадаадын агаарын тээврийн компанийн агаарын хөлгүүдэд нисэхийн аюулгүй ажиллагааг хангасан нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;



- 2.6.4.5. агаарын хөлгүүдэд нисэхийн аюулгүй ажиллагааг хангасан холбоо, навигаци, бодит ажиглалт, цахилгааны тоног төхөөрөмжийн найдвартай, тасралтгүй үйлчилгээ үзүүлэх;
  - 2.6.4.6. агаарын тээврийн компаниудад нислэгийн зөвшөөрөл олгох, нислэгийн хөдөлгөөний төлөвлөлтийг гүйцэтгэх, гүйцэтгэлд хяналт тавих;
  - 2.6.4.7. Монгол Улсын нисэхийн мэдээллийн бүсэд дотоод, гадаадын нисгэх баг түүнчлэн өөрийн орны болон гадаад орнуудын холбогдох байгууллагуудад бодит, үнэн зөв нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
  - 2.6.4.8. иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа холбоо, навигаци, бодит ажиглалтын тоног төхөөрөмжүүдийг баталгаажуулах.

#### 2.6.5. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

- 2.6.5.1. нисэх буудлын үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төсөл, стандартын санал боловсруулах, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангуулах;
  - 2.6.5.2. нисэхийн аюулгүй байдлын бодлогын санал, журам, заавар боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангуупах, аюулгүй байдлын ажилтнуудыг сургаж, дадлагажуулах;
  - 2.6.5.3. үйлдвэрлэл, үйлчилгээний технологийг боловсронгуй болгох, нисэх буудлуудын барилга байгууламж, аэродромын бэлэн байдлыг хангуулах, засвар, үйлчилгээнд мэргэжлийн хяналт тавих;
  - 2.6.5.4. нислэгийн цагийн хуваарийг зохицуулах;
  - 2.6.5.5. олон улсын болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх;
  - 2.6.5.6. газрын тусгай үйлчилгээний автомашин, тоног техеөрөмжийн үйлчилгээ үзүүлэх.

#### 2.6.6. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хурээнд:

- 2.6.6.1. салбарын эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд санал боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах;
  - 2.6.6.2. олон улсын агаарын тээврийн зах зээлд үндэсний агаарын тээвэрлэгчдийн ерсөлдөх чадвар, зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх санал боловсруулах;
  - 2.6.6.3. агаарын тээврийн үйлчилгээ болон терлийг өргөжүүлэх, тогтвортжуулах арга хэмжээ авах;
  - 2.6.6.4. агаарын тээврийн зорчигч, ачаа тээвэрлэлтийн үнэ, тарифын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохицуулах;
  - 2.6.6.5. агаарын харилцаа, эдийн засгийн зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах;
  - 2.6.6.6. ачаа, зорчигч тээвэрлэлтийн үнэ тариф, хөнгөлөлт, нөхөн олговор олгох талаар санал боловсруулах;

- 2.6.6.7. салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, салбарын хүрээнд гадаад орнууд, олон улсын байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.6.6.8. иргэний нисэхийн салбарын ўйл ажиллагаатай холбоотой асуудлаар гадаад улс болон олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах бэлтгэлийг хангах, олон талт гэрээнд нэгдэн орох, олон улсын гишүүн байгууллагуудын хамтын ажиллагааны оролцоог идэвхжүүлэхэд мэргэжлийн арга зүйгээр хангах, мэргэжлийн боловсон хүчин гадаадын улс орнуудад бэлтгэхтэй холбоотой гэрээ хийх;

2.6.6.9. иргэний нисэхийн салбарын статистикийн сан бүрдүүлэх, статистикийн үнэн бодит судалгаанд тулгуурласан мэдээллээр хэрэглэгчийг хангах.


## 2.6.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

- 2.6.6.1. төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
  - 2.6.6.2. ажилтнуудын хөдөлмөрийн харилцааг зохицуулж, нийт ажиллагсдын хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх, хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, холбогдох бусад мэдээллийг хугацаанд нь гаргаж тайлагнах;
  - 2.6.6.3. иргэний нисэхийн салбарын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах;
  - 2.6.6.4. хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, олон нийттэй харилцах, мэдээллийн ил тод байдлыг хангах;
  - 2.6.6.5. иргэний нисэхийн салбарын боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхийг сайжруулах тогтолцоог боловсронгуй болгох, хүний нөөцийн удирдлагаар хангах;
  - 2.6.6.6. салбарын ахмад настны нийгмийн хамгааллын холбогдолтой асуудлыг зохицуулах, зохистой шийдвэрлэх;
  - 2.6.6.7. байгууллагын албан хэрэг, хетлелтийг холбогдох хууль, стандарт, журмын дагуу тасралтгүй хөтлөн явуулах;
  - 2.6.6.8. зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн дотоод үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийг хангуулах, тайлагнах ажлыг уялдуулан зохицуулах;
  - 2.6.6.9. салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа узуулэх.

#### **2.6.7. Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:**

- 2.6.7.1. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад дотоод хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дунд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.6.7.2. Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдэж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах;



- 2.6.7.3. Төсвийн шууд захирагчийн эрхлэх ажлын хүрээний дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод хяналт, шалгалт, аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, мэдээллийн сан бурдуулэх, эрсдэлийн удирдлагаар хангах.

#### **2.6.8. Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хурээнд:**

- 2.6.8.1. төсвийн шууд захирагчийн хүрээний төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаад хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, зарцуулах, тайлагнах үйл ажиллагааг эрхлэн явуулах;

2.6.8.2. байгууллагын хагас жил, жилийн эцсийн тайланг үндэслэн эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийх, эдийн засгийн тоосцоо, судалгаа хийх, хөрөнгө оруулалтын бодлогын саналыг нэгтгэн боловсруулах;

2.6.8.3. хөрөнгө болон санхүүгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих, байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалтад бүртгэлээр хяналт тавих;

2.6.8.4. хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг бусад нэгжүүдтэй хамтран тодорхойлж, бодлогын саналыг нэгтгэн боловсруулах;

2.6.8.5. хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангах;

2.6.8.6. технологийн болон нийтийн үйлчилгээний автомашин, тээврийн хэрэгслээр хангах, үйлчилгээ үзүүлэх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хийх, сэлбэг хэрэгслээр хангах, тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа, бэлэн байдлыг хангах;

2.6.8.7. ажлын хэвийн орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмерийн хүнд, хортой ажлын байруудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, аж ахуйн үйл ажиллагааг эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй бараа материал, эд хөрөнгийн захиалга, хангат, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагааг хөсиуцах.

#### 2.6.9. Үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хурээнд:

- 2.6.10.1. иргэний нисэхийн салбарыг Үндэсний хөгжлийн болон Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт, баримт бичигт нийцүүлэн хөгжүүлэх бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах, удирдлагад мэргэжлийн дэмжлэг, туслапцаа үзүүлэх;
  - 2.6.10.2. салбарын дунд болон урт хугацааны төсөл, хөтөлбөрийг төлөвлөн тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлыг холбогдох нэлжтэй хамтран зохион байгуулах;
  - 2.6.10.3. иргэний нисэхийн чиглэлээр олон улсад хэрэгжиж буй дэвшилтээ техник, технологи, инновацийг судалж нэвтрүүлэх;
  - 2.6.10.4. төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг гадаадын зээл, тусламж, хамтарсан төсөл, хөтөлбөр, тер-хувийн хэвшлийн түншплэл болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээр шийдвэрлүүлэх;
  - 2.6.10.5. салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, чиглэлийн төсөл хөтөлбөрийг боловсруулах судалгаа хийх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах;

- 2.6.10.6. иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, холбоод зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах;

2.6.10.7. иргэний нисэхийн мэдээлэл, техник технологийн системийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, оролцогч талуудын харилцан үр ашигтай, бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэх;

#### 2.7.Үйл ажиллагааны стратегийн загвар:

Иргэний нисэхийн ерөнхий газрын ўйл ажиллагааны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна. /3.2-д үзүүлэв./

Гурав. Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1. ИНЕГ-ЫН бүтцийн еренхий тогтолцоог боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав. Үүнд:

3.1.1. ИНЕГ-ын стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (Иргэний нисэхийн өрөнхий газрын ўйл ажиллагаа, бүтцийн өрөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний ўйл ажиллагааны стратеги зорилттой үялдсан байх);

3.1.2. эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, харьяа алба, байгууллагын тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж, харьяа алба, байгууллага ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);


3.1.3. үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчмыг (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дур төрх харагдахуйц байх, тухайлбал газрын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4. оновчтой бүтцийг бий болгох, бүтцийн нэгж энгийн байх зарчим (газрын даргаас хамгийн доод нэгжээ хүртэл гурваас дээшгүй шат дамжулагатай байх);

3.1.5. тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохицой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтгээг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бутцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх. Энэ нь удирдлагын чиг үүрэг, боловсон хүчиний болон бусад неөцигт зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийт бурдуулсан байх);



3.1.6. Улс төрөөс ангид байх зарчим (ажилтнууд нь үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нэлөөлөлд автахгүй төвийг сахисан мэргэжлийн өндөр зөвлөгөө, дэмжлэг үйлчилгээ үзүүлэх.);

3.1.7. хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн өрөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).



### 3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

3.2.1. ИНЕГ-ын стратегийн зорилт, үйл ажиллагааны зорилтод тулгуурласан газрын үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:



Иргэний  
нисэхийн  
салбарт  
аюулгүй, үр  
ашигтай,  
тогтвэр  
той  
үйлчилгээ  
үзүүлэх;

Агаарын тээврийг  
хөгжүүлэхд чиглэсэн  
бодлого,  
зохицуулалтыг  
хэрэгжүүлэх;

- 2.6.5.1 салбарын эдийн засгийн хөгжлийн бодлогын хурзачд санал боловсруулах бодлогын хэрэгжилтийг хангах;  
2.6.5.2 олон угсын агаарын тээврийн зах зээлд үндэсний агаарын тээвэрлэлтийн бодлогын хадвар зах зээлийн балтаважийг нийгдүүлах санал боловсруулах;  
2.6.5.3 эгийрын тээврийн үйлчилгээ болон төрлийн аргажууллах тогтвэржүүлах арга хэмжээ авах;  
2.6.5.4 агаарын тээврийн зорчигч, ачваа тээвэрлэлтийн үнэ, тарифын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохицуулах;  
2.6.5.5 агаарын харилцааны эрх зүй, эдийн засгийн зохицуулалтын хэрэгжилтийг зохицьтэй, биелжилтийг хангуулах;  
2.6.5.6, ачваа, зорчигч тээвэрлэлтийн үнэ тариф, хангваглал, нехви олговор олгох талаар санал боловсруулах;  
2.6.5.7 салбарын тадваад харилцаа, хамтын ажиллагааг өргөзүүлэн хөгжүүлах, салбарын хуреэнд гадаад орнууд, олон улсын байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг корягуулаж дэмжэлэг үзүүлох;  
2.6.5.8 иргэний нисэхийн салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор тадаад улс болон олон улсын байгууллагатай гарсаа, хангажаар байгуулах, олон тагт гареэнд нэгдэн сохно, огом улсын гишүүн байгууллагуудын хамтын ажиллагааны оролцоог идэвхжүүлах, мэргэжийн боловсон хүчин, Багтэй мэргэжлийн арга зүйн зөвлөгөөгөөр хангах мэргажийн боловсор хүчинг тадаадын үгс орнуудад багтактэй хөлбөйтгөй гарсаа хийх;  
2.6.5.9 иргэний нисэхийн салбарын статистикийн сан буруулах, статистикийн үнэний бодит судалгахад түпгүүрласан мэдээллээр хэрэгжлийг хангах;

Төрийн захиргааны  
болон хүний нэвцийн  
удирдлагаар хангах

- 2.6.6.1, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах  
2.6.6.2 ажилтнуудын хеделмэрийн харилцааг зохицуулж, нийт ажиллагдан хувийн харал, тоо бүртгэлийн хедлэгээг хеделтвэн тайланы, холбогдох мэдээллийг хувацаанд нь таргаж тайланаах;  
2.6.6.3, иргэний нисэхийн салбарын ажилтнуудын ажиллаж нэхцэв, нийтийн баталгааг хангах;  
2.6.6.4 хүний нэвцийн удирдлагын манлайллыг хангах, олон нийттэй харилцаах, мэдээллийн тод байдлыг хангах;  
2.6.6.5 иргэний нисэхийн салбарын боловсон хүчин балтгах, мэргшүүлэх, чадвхийг сайжруулах тогтолцоог боловсронгуй болгох, хүний нэвцийн удирдлагын хангах;  
2.6.6.6 салбарын ахмад настны нийтийн хамгааллын холбогдолтой асуудлыг зохицуулах, зохистой шийдвэрлэх;  
2.6.6.7 байгууллагын албан хэрэг, хетвелтийг холбогдох хууль, стандарт, журмын давгу тасралтуудыг хангах, явуулах;  
2.6.6.8 зохион байгуулалтын бүтцийн нийжүүдийн дотоод үйл ажиллагааны төвлөвлөлт, гүйцэтгэлийг хонгиуулах, тайланаах ажлыг үзлдүүрен зохицуулах;  
2.6.6.9 салбарын үйл ажиллагааг хангах, мэдээллийн хэрэгслийр дамжуулсан олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, мэргжил, арга зүйн туслаасаа үзүүлж.

Хууль тогтоосож,  
бодлого, хөтөлбарьи  
хэрэгжилтийн явцад  
дотоод хяналт,  
шалгалт, аудит,  
хяналт-шинжилсээ  
хийж, үнэлгээ хийж,  
зөвлөмж гаргах,

- 2.6.7.1 Хууль тогтоосож, бодлого, хөтөлбөр төслийн хэрэгжилтийн явцад дотоод хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, үүдтэй хийх, үр дүнүү нь үзлэгээ веих, дүгнэлт, зөвлөмж гаргах;  
2.6.7.2 Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдэж байгаа хууль тогтоосожийн хэрэжжилт төслийн, пр төлбөр, орлогийн зарлаг, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрдлийн удирдлагынхангах;  
2.6.7.3 Төслийн шүүд захирчийн эрхлох ажлын хувьийн дотоод бүтцийн нийжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилсээ хийх, үр дүнүү үзлэгээ веих, дотоод хяналт, шалгалт, аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, мэдээллийн сан буруулах, эрдлийн удирдлагыг хангах;

Төслийг тогтоосон  
журмын дагуу үр  
ашигтай зарцуулах  
Хөрөнгө оруулалтын  
үр ашгийг  
дээшмлүүлэх;

- 2.6.8.1 төслийн шүүд захирчийн хувьийн төслийн санхүүгийн эдийн засаг, дотоод, гадаад хөрөнгө оруулалтыг төслийг төвлөвлөх, зарцуулах, тайланаах үйл ажиллагааг эрхгэн явуулах;  
2.6.8.2 байгуулалтын хөгжжил, жилийн эсийн тайланааг нийдэслэн эдийн засгийн байдалд дун шинжилгээ хийх, эдийн засгийн тооцоо, судалгаа хийх, хөрөнгө оруулалтад нийтэлжүүлж санхүүгийн ногтган болговсруулах;  
2.6.8.3 хөрөнгө болон санхүүгийн буруулаалт зарцуулалтад хяналт тайланааг байгуулалтын индексийн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалтад бүртгэлээр хяналт тайланааг;  
2.6.8.4 хөрөнгө оруулалтын хэрэгцээ шавьдэлгэгээ бусад нийжүүдийг хөмтран тодорхойжжиг, бодлогын саналыг ногтган болговсруулах;  
2.6.8.5 хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангах;  
2.6.8.6 технологийн болон нийтийн үйлчилгээний автомашин тээврийн хэрэгслийг хангах, үйлчилгээ үзүүлэх, тээврийн хэрэгслийн засваа үйлчилгээ хийх, солбаг хэрэгслийг хангах, тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааг, балан байдлыг хангах;  
2.6.8.7 ажлын хөвийн орчин, нехцэлийн буруулах, хеделмэрийн хүнд, хоргой шийн байрлуудад хеделмэрийн аюулгүй байдал, зруул ахуйн шавьдэлгэгээ хангах, аж ахуйн үйл ажиллагааг эрхлох, үйлдвэрлэх, үйлчилгээний нийжүүдийн үйл ажиллагааны хэрэгцээгийн барваа материал, эд хөвийн засагийг хангах, тэдээгээний хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагааг хариуцах.

Иргэний  
нисэхийн  
салбарт  
аюулгүй, үр  
ашигтай,  
тогтвор  
тай  
үйлчилсээ  
үзүүлэх.

иргэний нисэхийн  
салбарыг Үндэсний  
хөгжлийн бодлого, олон  
улсын чиг хандлагатай  
үялдуплан шинэчлэн  
хөгжүүлэх, инновацийн  
болон хөгжлийн  
бодлогааг боловсруулах,  
түүнчлээ чалзсан тасел,  
хөтөлбөрийнэ

2.6.9.1 иргэний нисэхийн салбарыг Үндэсний хөгжлийн болон Спорт улсын иргэний нисэхийн байгууллагыг (ICAС)-ын стандарт, баримт бичигт нийцүүлж хөжүүлэх бодлого, төслийн, хөтөлбөр болсовруулах, удирдлагадаад мэргэжлийн дэмжилэг, туслаачаа узүүлах;

2.6.9.2 салбарын дунд болсон тухайгаасаа төслийн, хөтөлбөрийг төгөвлөн тадгайджийн хэрэгжлийг хамгаалж чинийн түүрээг хийх аялж холбогдох нийтийг хамтарсан эсхион байгуулах;

2.6.9.3 иргэний нисэхийн чиглэгэрээр олон улсад хэрэгжиж буй дэвшилтэд техники, технологийн инновацийн судалж наструуллах;

2.6.9.4 төслийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг гадвадын эзлэх, туслаамж хамтарсан төслийн хөтөлбөр, төр-хувийн хөвчилтийн түүхэл болсон хуулиар зөвхөөрдөн бусад эх уссырзэр шинийн дээрүүлжүүлэх;

2.6.9.5 салбарын хүчин нийцийн хөгжлийн бодлого, чиглэлийн төслийн хөтөлбөрийг болсовруулах судалгаас хийх хэрэгжүүлэх төхөгт зохицсан байгууллах, хэрэгжилтийг хангтуулах;

2.6.9.6 иргэний нисэхийн салбарын хангнуулсаа төслийн хөтөлбөрийн хэрэгжүүлжүүд гадвад, дотосдын мэргэжлийн байгууллага, холбоод зэрэг орлогчтой талгуудын хамтын ажиллагаагаа хангах;

2.6.9.7 иргэний нисэхийн мэдээлэл, техникийн технологийн системийн нэгдсэн тогтолцоогоор бүрдүүлэх, орлогчтой талгуудын харилцаан үр ашигтай, бутаачийн хамтын ажиллагааг хангтуулна.

3.2.2. Үйл ажиллагааны бүтцийн загвар нь үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтцийн нэгжийн болон шаардлагатай албан тушаал (ажлын байр)-ын хэрэгцээг тодорхойлох гол үндэслэл болж байна. Энэхүү бүтцийн загварын хүрээнд үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай албан тушаал буюу орон тооны хэрэгцээг тодорхойлон гаргана.

### 3.3 Зохион байгуулалтын бүтэц

Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд мөн хуулийн 8.4.6 дахь заалтад иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь өөрийн шууд харьяа алба, байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлахаар заасан билээ.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-д агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хотолбөр болон зохион байгуулалтын бүтцийг Засгийн газраас тогтоосон ерөнхий загварыг баримтлан Монгол Улсын сайд, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т зааснаар төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус тогтоосоор заасантай уялдуулан ИНЕГ-ын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн чиг үүргийг дор дурдсанаар тодорхойлж байна


ИНЕГ нь Дарга, Тэргүүн дэд дарга, Дэд дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга гэсэн удирдлагатай байна. Даргын шууд удирдлагад 4 газар, 1 алба, Тэргүүн дэд даргын удирдлагад 2 газар, 1 хэлтэс, Дэд дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны даргын удирдлагад 1 алба, 4 хэлтэс байхаар тус тус зохион байгуулахаар загварыг гаргав.

#### 3.3.1. Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа агаарын тээвэрлэгч нисэх компанийдад нислэгт тэнцэх чадвар хангахад чиглэсэн мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хийх, агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох, нислэгийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих, аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх зөвлөмж, шаардлагыг боловсруулж хүргүүлнэ.

Мөн онцгой, тусгай үүргийн нислэгийн бэлтгэл ажлын болон нислэгийн явцад тогтмол хяналт тавих, нислэгийн үйл ажиллагааны холбогдох баримт бичгийг баталгаажуулах, зөвшөөрөл олгох, иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох, сунгах, бүртгэлээс хасах, агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварыг гэрчилгээжүүлэх, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, агаарын хөлөг, түүнд хамаарах эд ангийн ашиглалтын хугацааг сунгах, ашиглалтын журам, заавар, технологийн баримт бичгүүдийг баталгаажуулна.

Нисэхийн үйлчилгээний байгууллагууд болох азродром, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, агаарын навигацийн техникийн байгууллагын үйлчилгээ, нислэгийн журмын үйлчилгээ, нисэхийн цаг уурын үйлчилгээ, нисэхийн мэдээллийн үйлчилгээ, шатахуун, хангамж, техник үйлчилгээ, зохион бүтээгч байгууллагын, үйлдвэрлэгч байгууллагын, ачаа тээвэр зуучлал, сургалтын болон үйлчилгээний бусад байгууллагыг гэрчилгээжүүлэх, гэрчилгээг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сургалтын хөтөлбөрийг хянаж баталгаажуулах, иргэний нисэхийн мэргэжлийн ажилтныг үнэмлэхжүүлэх, онолын болон мэргэжлийн үр чадварт дүгнэлт гаргах, иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээнд ашиглагдах тоног төхөөрөмжүүдийн ашиглалтад тэнцэх гэрчилгээ олгох, сунгах, хүчингүй болгох чиг үүргийг хэрэгжүүлнэ.



Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь иргэний нисэхийн багц дүрмийн дагуу үйл ажиллагаа эрхлэх агаарын тээврийн компаниуд, иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч компаниуд байна.

Энэ нэгж нь нислэгийн стандарт үйл ажиллагааны хяналт, нислэгт тэнцэх чадвар, аэродром, агаарын навигацийн хяналт, үнэмлэх, гэрчилгээжүүлэлт зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэцтэй байна.

### 3.3.1.1. Нислэгийн стандарт үйл ажиллагааны хяналт хариуцсан нэгж

Энэ нэгж нь иргэний нисэхийн багц дүрмийн хүрээнд үндэсний агаарын тээвэрлэгчид, Монгол Улс руу арилжааны нислэг үйлдэж буй гадаадын агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа болон ачаа тээвэр зуучийн байгууллагыг гэрчилгээжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, гэрчилгээжсэн байгууллагуудын үйл ажиллагаанд байнгын хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ.

Агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх болон гэрчилгээ зээмшигчдэд хийх аюулгүй ажиллагааны аудит шалгалтыг дараах үндсэн чиглэлээр явуулж, нислэгийн стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуйж, холбогдох баримт бичгүүдийг хянан баталгаажуулах ажлыг хариуцна. Үүнд:

- Нислэгийн аюулгүй ажиллагааны бичиг баримтын тогтолцоо
- Аюулгүй ажиллагааны удирдлага ба чанар баталгаажуулалтын тогтолцоо
- Нисэх багийн сургалтын хөтөлбөр, багийн гишүүдийн дадлага, туршлага
- Агаарын хөлгийн дисплетчериин сургалтын хөтөлбөр
- Бүхээгийн аюулгүй ажиллагаа, агаарын хөлгийн үйлчилгээний сургалтын хөтөлбөр
- Газрын үйлчилгээний зохицуулалт /тээвэр зохион байгуулалт, зорчигч ачаа тээш/
- Аюултай ачаа тээвэрлэлт
- Агаарын хөлгийн түрээсийн зөвшөөрөл.

### 3.3.1.2. Нислэгт тэнцэх чадварын хяналт хариуцсан нэгж


Энэ нэгж нь агаарын хөлөг, түүний техник үйлчилгээтэй холбоотой стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хангуйж, нислэгт тэнцэх чадварын хадгалалт, техник үйлчилгээний журам, заавар, технологийн баримт бичгүүдийг хянан баталгаажуулах ажлыг хариуцна.

Мен агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, нислэгт тэнцэх чадварын хяналт, агаарын хөлөг, агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрөх, агаарын хөлгийн техник үйлчилгээний болон шатахуун хангамжийн байгууллагыг гэрчилгээжүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.1.3. Аэродром, агаарын навигацийн хяналт хариуцсан нэгж

Энэ нэгж нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, агаарын навигацийн техникийн үйлчилгээ, нислэгийн журмын үйлчилгээ, нисэхийн мэдээллийн үйлчилгээ, нисэхийн цаг уурын үйлчилгээ, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ, аэродромын үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудыг иргэний нисэхийн багц дүрмийн дагуу гэрчилгээжүүлэх, гэрчилгээг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, холбогдох стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хангуйж, үйл ажиллагааны журам, заавар, технологийн баримт бичгүүдийг хянаж хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах ажлыг хариуцна.

Мен иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээнд ашиглагдах тоног төхөөрөмжүүдийн ашиглалтад тэнцэх гэрчилгээ олгох, сунгах, хүчингүй болгох, аэродром, агаарын навигацийн хангалт үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний удирдлагын технологи, агаарын зайн зохион байгуулалт, нислэгийн төлөвлөлт, нислэгийн мэдээллийн хангалт,



агаарын навигаци, нисэхийн холбоо, ажиллалтын систем, шалгалтын нислэг, аэроромын засвар, үйлчилгээний технологи, аэроромын перроны менежмент, газрын үйлчилгээний технологи, нисэхийн цаг уурын хангарт, нисэхийн аюулгүй байдлын хангарт зэрэг үйл ажиллагааны хангарт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.1.4. Үнэмлэх, гэрчилгээжүүлэлт хариуцсан нэгж

Иргэний нисэхийн мэргэжлийн ажилтанд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл олгох, эрүүл мэндийн гэрчилгээ олгох, энэ хүрээнд онолын болон мэргэжлийн ур чадварын шалгалт авч дүгнэлт гаргах, итгэмжлэгдсэн шалгагч, итгэмжлэгдсэн байгууллагыг томилс, өөрчлөх талаар санал дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагааар хэрэгжинэ. Иргэний нисэхийн сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

Тус нэгж нь иргэний нисэхийн салбарын инженер, техникийн ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээ олгохтой холбоотой стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, үзлэг шалгалтыг зохион байгуулах ажлыг хариуцна.

### 3.3.2. Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд иргэний нисэхийн хууль тогтоомж, Олон улсын гэрээ хэлцэл боловсруулах, хууль эрх зүйн холбоотой бусад баримт бичигт санал өгөх, ИНЕГ-ын удирдлага, ажилтнуудад эрх зүйн туслалцаа үзүүлэх, ИНЕГ-аас боловсруулан гаргаж байгаа эрх зүйн баримт бичгийн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шүүхийн маргаантай асуудлаар шүүх, хууль хяналтын байгууллагад ИНЕГ-ыг төлөөлж оролцох, иргэний нисэхийн хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.


Мөн Чикагогийн конвенцийн Хавсралтад заасан стандартын минимум суурь түвшинг хангасан, Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд тохирсон, хэрэгжүүлэх боломжтой, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны зохицуулалтын дүрэм, зөвлөмжийн цуврал, маяг болон бүртгэлийн дэвтрүүг жишиг дүрмийн дагуу боловсруулах, тогтолц шинэчлэх болон дүрмийн шаардлагаас чөлөөлсөн бүртгэлийг зарлахтай холбоотой ажлуудыг хийх, зөвлөмжийн цуврал, маяг, бүртгэлийн дэвтэр, танилцуулга материал гаргаж, салбарын хэрэглэгчдийг үнэн зөв эрх зүйн мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяя алба, байгууллагууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Зам, тээврийн хөгжлийн яам, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох талууд нь Зам, тээврийн хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам байна.

Энэ нэгж нь иргэний нисэхийн багц дүрэмд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжтэй байна.

### 3.3.2.1. Дүрмийн боловсруулалт хариуцсан нэгж

Энэ нэгж нь иргэний нисэхийн хууль тогтоомж боловсруулахад мэргэжлийн арга зүйгээр хангах, бүх талын дэмжлэг үзүүлэх, Чикагогийн конвенцийн Хавсралтуудын нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан иргэний нисэхийн багц дүрмийг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, салбарын стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох, иргэний нисэхийн хууль, тогтоомж, зөвлөмжийн цувралын мэдээлэл, лавлагaa, сурталчилгааг гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.



### 3.3.3. Агаарын навигацийн бодлого, зохицуулалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2, 3 дугаар зорилтын хүрээнд агаарын навигацийн үйлчилгээний ойрын болон хэтийн чиг хандлагыг тодорхойлох, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, агаарын зайд, агаарын замын сүлжлийг төлөвлөх, зохион байгуулах, нислэгийн төлөвлөлт, зохицуулалт, агаарын навигацийн үйлчилгээний зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног навигацийн төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоос судалгаа хийх, хангалтыг зохион байгуулах, Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүрх олон улсын нислэгийн өнгөрөлт, дамжин тээвэрлэлтийн хэмжээг есгэх арга хэмжээ авах, агаарын навигацийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Агаарын тээвэрлэгчдийн нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэлд судалгаа хийж, нислэгийн зөвшөөрөл олгох, нислэгийн хөдөлгөөний төлөвлөлт, орон нутаг, олон улсын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, холбоо, навигаци, бодит ажиглалтын үйлчилгээний хангарт, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт болон нислэгийн зураглал хийх, шалгалтын нислэгийн үйл ажиллагаа, эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг зохицуулах, шуурхай мэдээллээр хангах, агаарын навигацийн буюу нисэхийн мэдээллийн үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, технологийн баримт бичгийн шинэчлэлт, боловсруулалт, баталгаажуулалтын ажлыг хариуцан хэрэгжүүлнэ.

Агаарын навигацийн үйлчилгээний хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах асуудлыг хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж нь ИНЕГ-ын Тэргүүн дэд даргын шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах бөгөөд үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь дарга, дэд дарга гадаад, дотоодын агаарын тээвэрлэгч, бусад хэрэглэгчид байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч нь Зам, тээврийн хөгжлийн яам байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээ, нисэхийн мэдээллийн үйлчилгээ, нислэгийн журам боловсруулалт, оношилгоо, хэмжил зүй, нислэгийн ургал төлөвлөлт хариуцсан нэгжүүд ажиллана.


#### 3.3.3.1. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ хариуцсан нэгж

Тус нэгж нь Монгол Улсын агаарын зайд орон нутаг, олон улсын агаарын шугамд нислэг үйлдэж буй дотоод, гадаадын агаарын тээврийн компанийн агаарын хөлгүүдэд нисэхийн аюулгүй ажиллагааг хангасан нислэгийн хөдөлгөөний удирдлагын болон эрэн хайх, авран туслах 24 цагийн тасралтгүй үйлчилгээ үзүүлэх, нислэгийг өгөгдсөн захиалгын дагуу төлевлен зохицуулах, нислэгийн гүйцэтгэлийн мэдээллийг гаргах, нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажлын технологийг боловсронгуй болгох замаар агаарын зайд сонвчтой ашиглах үүргийг хэрэгжүүлнэ.

Тус нэгж нь иргэний нисэхийн багц дүрэм ИНД-172 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт"-ийн дагуу гэрчилгээжсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

#### 3.3.3.2. Холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээ хариуцсан нэгж

Энэ нэгж нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж буй дотоод, гадаадын нисэх компанийн агаарын хөлгүүдэд нисэхийн аюулгүй ажиллагааг хангасан газрын холбоо, навигаци, бодит ажиглалтын систем, цахилгааны тоног төхөөрөмжийн найдвартай, тасралтгүй хангарт, үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.



Тус нэгж нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэж буй агаарын хөлгүүдийг агаар-газрын радио холбоогоор хангах, агаарын хөлгүүдийг чиглүүлэх, навигацийн болон бодит хяналтын системээр хянах, агаарын навигацийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хариуцах, хөрш зэргэлдээх орнуудын нисэх байгууллагуудтай тоон болон дун холбоогоор харьцах харилцаа, холбооны үйлчилгээг гүйцэтгэх, төв, орон нутгийн нисэх буудлуудын технологийн холбоо, гэрэл суултын систем, цахилгаан хангамжийн үйлчилгээг хариуцан, Бүянт-Хаа дахь байгууллага, аж ахуйн нэгжүүдэд цахилгаан хангамж, телефон холбоо, интернет гэсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, иргэний нисэхийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа төв, срон нутгийн техникийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг хариуцах үндсэн үүрэгтэй.

Тус нэгж нь ИНД-171 "Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллага, гэрчилгээжүүлэлт"-ийн дагуу гэрчилгээжсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

### 3.3.3.3. Нисэхийн мэдээллийн үйлчилгээ хариуцсан нэгж

Энэ нэгж нь иргэний нисэхийн үйлчилгээ, үйл ажиллагаатай холбогдол бүхий мэдээлэл цуглуулах, боловсруулах, тараах, солилцох, нисэхийн мэдээллийн үйлчилгээ (NOTAM, AIP) үзүүлэх, аэродром, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалттай холбоотой мэдээлэл, Монгол Улсын нисэхийн мэдээллийн бусад дотоод, гадаадын агаарын тээвэрлэгч, холбогдох байгууллагуудад нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тус нэгж нь ИНД-175 "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт"-ийн дагуу гэрчилгээжсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

### 3.3.3.4. Нислэгийн журам боловсруулалт хариуцсан нэгж

Энэ нэгж нь нислэгийн ил харааны болон хэрэглэлийн нислэгийн схем боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, иргэний нисэхийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа холбоо, навигацийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг шалгалтын нислэгээр хэмжилт, тохируулга хийн баримтжуулах, ашиглалтын хугацааг баталгаажуулах, гэрчилгээжүүлэх нэхцэлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.


Тус нэгж нь ИНД-173 "Нислэгийн журмын үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт"-ийн дагуу гэрчилгээжсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

### 3.3.3.5. Оношилгоо, хэмжил зүй хариуцсан нэгж

Оношилгоо, хэмжил зүйн лаборатори нь нисэхийн аюулгүй, тогтмол үйл ажиллагааг хангуулах зорилгоор иргэний нисэхийн салбарт ашиглагдаж байгаа цаг уурын автомат станцын баталгаажуулалт, радио болон цахилгааны хэмжих хэрэгслийдийн шалгалт, тохируулга, ачаа тээшний жингийн баталгаажуулалт, газардуултын хэмжилт, аэродромын бус 1, бус 2, бус 3-ын саадын болон байршилын хэмжилт, шатахуун хадгалах савны наасжилт тодорхойлох, багтаамжийн хэмжилт, баталгаажуулалт, сүмбэн метр, туузан метр баталгаажуулалт, агаарын хөлгийн их биений хэв тажилтын хэмжилт, жин ба төвлөрөлтийг тодорхойлох, үл эвдэх сорилын аргуудаар үзлэг шалгалт гүйцэтгэх, нефтийн бүтээгдэхүүний чанарын иж бүрэн шинжилгээ, шилэн хэмжүүрийн баталгаажуулалт зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

### 3.3.3.6. Нислэгийн урсгал төлөвлөлт хариуцсан нэгж

Энэ нэгж нь нислэгийн хөдөлгөөний урсгалын менежментийг хэрэгжүүлэх стратеги зорилтын хүрээнд нислэгийн хөдөлгөөний урсгал, төлөвлөлтийн ойрын болон хэтийн чиг хандлагыг тодорхойлох, холбогдох баримт бичгийг боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нислэгийн төлөвлөлт, урсгал зохицуулалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийгдэх олон улсын нислэгийн өнгөрөлт, олон улсын буулт, хөөрөлт болон



орон нутгийн нислэгүүдэд зөвшөөрөл олгох, шуурхай төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгж нь агаарын тээвэрлагчдийн ирүүлсэн нислэгийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлд судалгаа хийж, нислэгийн зөвшөөрөл олгох, нислэгийн хөдөлгөөний төлөвлөлтийн баримт бичгийн шинэчлэлт, боловсруулалт, баталгаажуулалтын ажлыг хариуцан хэрэгжүүлнэ.

### 3.3.4. Нисэх буудлуудын удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2, 4 дүгээр зорилтын хүрээнд нисэх буудлуудын дэд бүтэц, асуултгүй байдал, тээвэр зохион байгуулалт, аэродром, газрын үйлчилгээг сайжруулах чиглэлээр ойрын болсны хэтийн чиг хандлагыг тодорхойлох, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, нисэх буудлуудыг хөгжүүлэх талаар гарсан бодлогын хэрэгжилтийг хангуулах, нисэх буудлуудын агаарын тээвэрлэлтийн үйл ажиллагааны эдийн засгийн үзүүлэлтэд судалгаа шинжилгээг хийх, олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Мөн хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо судалгаа хийх, үйлдвэрлэл, үйлчилгээний технологийг боловсронгуй болгох, "Чингис хаан" олон улсын нисэх буудал, орон нутгийн нисэх буудлуудыг мэргэжлийн удирдлагын зохион буудлуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт, зохицуулалтыг гүйцэтгэх, тоног төхөөрөмжүүдийн байнгын бэлэн байдлыг хангах, нисэх буудлын барилга байгууламж, аэродромын засвар үйлчилгээнд хяналт тавих, ашиглалтын байдлыг хариуцах, аэродром болон газрын үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах асуудлыг хариуцна. Мөн Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль болон Хөдөлмерийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.


"Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр", "Агаарын тээврийг хялбаршуулах хөтөлбөр"-т нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулалтаар хангах, агаарын хөлгийн буулт, хөөрөлтийн хөдөлгөөн, зорчигч, ачаа зргэлтийн талаар судалгаа хийж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, тухайн нисэх буудлын хүчин чадалд тулгуурлан тогтмол нислэгийн цагийн хуваарийг нэгтгэх, санал авах, батлах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тус нэгж нь ИНЕГ-ын даргын шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах бөгөөд үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь дарга, дэд дарга, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжүүд, гадаад, дотоодын агаарын тээвэрлагч, бусад хэрэглэгчид байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвшн нь Зам, тээврийн хөгжлийн яам, нутгийн захиргааны байгууллага, иргэд байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд олон улсын нисэх буудал, орон нутгийн нисэх буудлууд, газрын үйлчилгээ хариуцсан нэгж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах нэгж, аюулгүй байдал, хамгаалалтын нэгж тус тус ажиллана.

#### 3.3.4.1."Чингис Хаан" Олон улсын нисэх буудал

"Чингис хаан" олон улсын нисэх буудал нь олон улсын стандарт, шаардлагад нийцсэн нисэх буудлын үйлчилгээг зорчигчдод үзүүлэх, ачаа, тээш, шууданийн бүрдүүлэлт, тээвэрлэлтийг зохион байгуулах, аэродромын бэлэн байдлыг хангаж, галын аюулгүй байдал болон нисэхийн аюулгүй байдлыг хангах, нисэх буудлуудаар үйлчлүүлж байгаа агаарын хөлөгт газрын үйлчилгээ үзүүлэх, нисэх буудлын тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа явуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Мөн тус нисэх буудал нь ИНЕГ-ын харьяа байгууллагуудын сантехник, дулаан хангамж, цэвэр бохир усны хангалт, үйлчилгээ, засварын ажлыг хариуцан гүйцэтгэнэ.



### 3.3.4.2. Орон нутгийн нисэх буудлууд

ИНЕГ-ын харьяанд орон нутгийн 19 нисэх буудал үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн нисэх буудлууд нь агаарын тээвэрлэгч, агаарын хөлгөөр зорчигчдод нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, ачаа, тээш, шуудангийн бурдүүлэлт, тээвэрлэлтийг зохион байгуулах, агаарын хелэгт бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх, газрын холбоо, навигаци, цахилгааны хангалаар хангах, тоног төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгах, засвар үйлчилгээ, ашиглалтын байдлыг хариуцах, аэродромын ашиглалтын болон газрын үйлчилгээний бэлэн байдал, аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нисэх буудлууд нь зорчигчдод тав тухтай үйлчилгээ үзүүлэх, галын аюулгүй байдал болон нисэхийн аюулгүй байдлыг хангах, нисэх буудлын тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа явуулахад чиглэсэн үзлэг, шалгалт, хяналт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.3.4.3. Газрын тусгай үйлчилгээ хариуцсан нэгж

Энэ нэгж нь олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын газрын тусгай үйлчилгээний бэлэн байдлыг хангах, авто машин, тээврийн хэрэгслээр хангах, үйлчилгээ үзүүлэх, төв орон нутгийн аэродромын засвар арчлалт, технологийн үйлчилгээний автомашинуудад засвар үйлчилгээ гүйцэтгэх, сэлбэг хэрэгслээр хангах, шатахууны сав, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хариуцах, агаарын хөлгийн шатахуун, түлшийг технологийн дагуу татах, тээвэрлэх, нөөцлөх, хадгалах, агаарын хөлгийн шатахуун сумалгааны үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй байдлыг ханган хийж гүйцэтгэх, агаарын хөлгийн шатахууны шинжилгээ хийх лабораторийн тогтмол хэвийн ажиллагааг хангах, шатахууны тоо, чанарын хяналтыг хариуцан ажиллах үндсэн чиг үүрэгтэй.


Мен үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох, газрын тусгай үйлчилгээний зохион байгуулалтыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага ICAO-/ын стандарт, зөвлөмж, Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо IATA/-ны агаарын хөлгийн газрын үйлчилгээний байгууллагад тавигдах шаардлагад нийцсэн эрх зүйн баримт бичиг боловсруулах, газрын үйлчилгээ эрхэлж буй байгууллагууд болон нисэх буудал хосонд газрын үйлчилгээний чиглэлээр харилцан ажиллах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

### 3.3.4.4. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захираганы нэгж;

Энэ нэгж нь Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад оруулах бэлтгэлийг хангах үйл ажиллагааг Монгол Улсын болон олон улсын холбогдох хууль, журмын хүрээнд чанар, стандартын түвшинд хийж гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй. Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эрхлэх оператор компани байгууллагдах хүртэл хугацаанд барилга байгууламж, объектуудын бүрэн бүтэн байдал, дэд бүтгийн бэлэн байдлыг хангаж, эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэд бүтэц, техник ашиглалтын үйл ажиллагааны чиглэлээр төсөл хэрэгжүүлэх нэгж, зөвлөх компани, гүйцэтгэгч байгууллага, Жайка олон улсын хамтын ажиллаганы байгууллагын зөвлөхүүд, төрийн хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах, иргэний нисэхийн бодлого, зорилтод нийцүүлэн шинэ нисэх буудлын үйл ажиллаганы төлөвлөлт, аэродром, нислэг үйлдвэрлэлийн төлөвлөлтийг оновчтой хийх, шинэ нисэх буудал руу нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.4.5. Аюулгүй байдал, хамгаалалт хариуцсан нэгж:

Энэ нэгж нь иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын төлөвлөлт зохицуулалт хяналтыг хэрэгжүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагааны



зааврыг боловсруулж, хэрэгжилтийг хангах, аюулгүй байдлын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, нисэх буудлын хориотой, хамгаалагдсан бүсэд байнгын болон түр, нэг удаагийн үнэмлэх олгох, хяналт тавих, аюулгүй үзлэгийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, бэлэн байдлыг хангах, нэвтрэх үнэмлэхний хяналтын систем, дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн нисэх буудлын хориотой, хамгаалагдсан бусийн аюулгүй байдлыг хангах, Иргэний нисэхийн аюулгүй байдлын эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангуулах, нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагаатай холбоотой зөрчил, дутагдлыг яаралтай таслан зогсоох, саармагжуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах, онцгой байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед нэгжийн бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангах, нисэхийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үүрэг хүлээсэн байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **3.3.5. Агаарын тээврийн бодлого, төлөвлөлт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**


Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2, 5 дугаар зорилтын хүрээнд салбарын эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, агаарын тээврийг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөгжлийн бодлогын санал боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах, агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын эрх зүйн баримт бичгийг боловсруулах, олон улсын агаарын тээврийн зах зээлд үндэсний агаарын тээврлэгчдийн өрсөлдөх чадвар, зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийх, агаарын тээврийн үйлчилгээ болон төрлийг өргөжүүлэх, тогтвортжуулах чиглэлээр судалгаа хийх, санал боловсруулах, салбарын эдийн засгийн статистик мэдээ гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Салбарын үйлчилгээний үнэ тарифын талаарх бодлогын хэрэгжилтийг зохицуулж, нисэх буудлын хураамж, агаарын навигацийн үйлчилгээний үнэ тарифыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Doc 7100 "Нисэх буудлын хураамж болон агаарын навигацийн үйлчилгээний тариф" баримтад нийцүүлсэн эсэхэд хяналт тавих, агаарын тээвэрлэгчдийн санхүү-эдийн засгийн байдалд дун шинжилгээ хийх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнийг хориглох талаар өрсөлдөөнийг хянах байгууллагатай хамтран ажиллах, агаарын тээвэрлэгчдийн тарифт дун шинжилгээ хийж дотоодын тарифыг батлахад санал боловсруулах, агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээтэй холбоотой асуудлаар зохицуулалт хийх үндсэн үүрэгтэй.

Мөн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын төлөөлөгчдийн айлчлал, ИНЕГ-ын удирдлагын гадаадын төлөөлөгчдийтэй хийх уулзалт, гадаадад хийх айлчлалын бэлтгэлийг хангаж, ёслол протоколыг гүйцэтгэх, салбарын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн баримт бичгийг холбогдох нэгж, байгууллагатай хамтран боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, Засгийн газар хоорондын болон олон талын хэлэлцээрт салбарын чиглэлээр тусгуулах саналыг нэгтгэн хүргүүлэх, гадаадын байгууллагуудтай харилцах асуудлыг зохицуулах, зөвлөгөө өгөх үндсэн үүрэгтэй, чиг үүргийг хэрэгжүүлнэ. Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр шинээр байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулахад Зам, тээврийн хөгжлийн яаманд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн боловсон хүчин гадаадын улс орнуудад бэлтгэхтэй холбогдуулан холбогдох байгууллагуудтай гэрээ, хэлэлцээр хийх ажлыг хариуцна.

ИНЕГ-ын даргын шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах бөгөөд үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь удирдах дээд шатны байгууллагууд, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, агаарын тээвэрлэгчид, бусад хэрэглэгчид байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд эдийн засгийн зохицуулалтын нэгж, агаарын харилцааны нэгж ажиллана.



### 3.3.5.1. Эдийн засгийн зохицуулалтын нэгж:

Энэ нэгж нь агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын бодлогын санал боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах, иргэний нисэхийн эдийн засгийн холбогдолтой дүрмүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих, салбарын үйлчилгээний үнэ тарифын талаарх бодлогын хэрэгжилтийг зохицуулах, агаарын тээврийн гадаад, дотоод орчны судалгаа, шинжилгээ хийх, агаарын тээврийн зах зээлийн хэмжээ, багтаамжийг тодорхойлж, агаарын тээврийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн дотоодын агаарын тээврийн байгууллагуудын санхүү, эдийн засгийн байдал, үнэ тарифт дүн шинжилгээ хийж, дотоодын тарифыг батлахад санал боловсруулах, агаарын тээвэрлэлтийн статистик мэдээллийг боловсруулах, иргэний нисэхийн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, үйлчилгээний чанарт хяналт тавьж, шаардлагатай зохицуулалтын арга хэмжээг авч ажиллана.

### 3.3.5.2. Агаарын харилцааны нэгж:

Энэ нэгж нь гадаад улс орнуудын Засгийн газартай Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулах, хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, Олон улсын иргэний нисэхийн салбарт Монгол Улсын баримтлах бодлого боловсруулах, агаарын тээвэрлэгч компаниудын томилгос, гадаад зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой бодлого боловсруулах, иргэний нисэхийн олон улсын мэргэжлийн байгууллагууд болон гадаад орнуудын иргэний нисэхийн удирдах байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ИНЕГ-ын гадаад арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гадаад орнуудын тэтгэлэгт хөтөлбөрт ажилтнуудыг хамруулахад дэмжлэг үзүүлэх, гадаад улс, олон улсын байгууллагуудын шугамаар болон гадаад хамтын ажиллагааны чиглэлээр зохиогдох хурал, зөвлөгөөн, бага хурал, сургалт, семинар, үзэсгэлэнд оролцох, зохион байгуулах, удирдлагууд болон ажилтнуудын гадаад албан томилолтын үйл ажиллагааг зохицуулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, үр дүнг тооцож тайлагналтыг хангуулах ажлыг хариуцна


### 3.3.6. Захиргаа удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн б дугаар зорилтын хүрээнд захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь байгууллагын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй, шуурхай байдлыг хангахад чиглэгдэнэ. Энэ нь тус газрын дотоод үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлж үр дүнгийн гэрээ байгуулах, түүний биелэлт, үр дүнг тооцох, байгууллагын соёл, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах, ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах замаар хэрэгжинэ.

ИНЕГ-ын даргын шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах бөгөөд үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяа алба, байгууллагууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Зам, тээврийн хөгжлийн яам, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд сургалт, амралт, хэвлэх үйлчилгээ үзүүлэх нэгжүүд тус тус ажиллана.



### 3.3.6.1. Нисэхийн сургалтын төв

Энэ нэгж нь иргэний нисэхийн салбарын мэргэжилтэй ажилтан давтан сургах, мэргшүүлэх, дадлагажуурын ажлыг хариуцахаас гадна Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт, шаардлага, зөвлөмжүүдэд нийцүүлэн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлнэ. Иргэний нисэхийн олон улсын стандарт, шаардлагын дагуу төв нь холбогдох багц дүрмийн дагуу гэрчилгээжсний үндсэн дээр үйл ажиллагааг явуулна.

### 3.3.6.2. Сэргээн засах амплит

Энэ нэгж нь Иргэний нисэхийн салбарын ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, салбарын эзлжийн зохион байгуулалтаар ажилладаг болон ажлын хэвийн бус нехцөлд олон цагаар ажилладаг ажилтнуудыг амрааж, сувилахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

### 3.3.6.3. Хэвлэх цэх

Энэ нэгж нь Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн албан ажлын хэрэгцээний бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийг цаг хугацаанд нь чанартай, тасралтуй хэвлэж тусгах ажиллагааг хэрэгжүүлна.

3.3.7. Дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг


Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын санхүү, төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, талбэр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах болон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, зөвлөмж гаргах замаар удирдлага болон бусад хэрэглэгчдийг цаг үеэс олсон мэдээллийн хангаж, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн үүргийг хэрэгжүүлнэ. Мөн авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

ИНЕГ-ЫН даргын шууд удирдлагад үйл эжиллагаа явуулах бөгөөд үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжкүд, бусад хэрэглэгчил байна.

**3.3.8. Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн уурэг, чиг уурэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөргүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бодлогод хөрөнгө, төсвийн төлөвлөлтийг туслах, хэрэгжүүлэх орчин, нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. ИНЕГ-ын санхүү, төлөвлөлтийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, нэгдсэн төсвийг төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийх, зохион байгуулалтын бүтцийн нагжүүдийн үйл ажиллагааны орлого, зарлагын төсвийг төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын оногчтой бодлогыг төлөвлөн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлна.

Дээрх чиг үүргийн хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр санхүүгийн нэгдсэн тайлан гаргах, хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулалтад хяналт тавих, хэрэгжилтийг хангах, байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалтад бүртгэлээр хяналт тавих, зардлын гүйцэтгэлийг төсөв төлөвлөгөөний дагуу зарцуулж байгаад санхүүгийн хяналт тавих чиг үүргийг харгалжуулна.



ИНЕГ-ын даргын шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах бөгөөд үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, бусад хэрэглэгчид байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэл, худалдан авах ажиллагаа, үйлчилгээ, аж ахуйн нэгжүүд тус тус ажиллана.

### 3.3.8.1. ИНЕГ-ын үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэл хариуцсан нэгж

Энэ нэгж нь ИНЕГ-ын үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжүүдийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хөтөлөх асуудлыг хариуцан ажилладаг.

Үйлдвэрлэлийн салбаруудын жил бурийн орлого, ургал зардлын төлөвлөгөөг боловсруулах, батлагдсан зардлыг үр ашигтай зарцуулахад ажлаа чиглүүлж, ажиллагсдын цалин хөлсийг цаг хугацаанд нь бодож олгох санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж, ашиглагдаж буй үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад бүртгэлээр хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалтаар хангахад чиглэнэ.

### 3.3.8.2. Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан нэгж

Энэ нэгж нь хөрөнгө оруулалтын бодлогын саналыг нэлгэн боловсруулах, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, захиалга, төлөвлөлтийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд мэргэжлийн хяналт тавих, тайлан гаргах чиг үүргийг хэрэгжүүлна.

ИНЕГ-ын даргын шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах бөгөөд үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь дарга, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжүүд, бусад хэрэглэгчид байна.

### 3.3.8.3. Үйлчилгээ, аж ахуйн нэгж:


Энэ нэгж нь ажлын хэвийн орчин, нохцелийг бүрдүүлэх, аж ахуйн үйл ажиллагааг эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй бараа материал, эд хөрөнгийн захиалга, хангарт, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ.

ИНЕГ-ын дотоод харьяа бүтцийн нэгжүүдийн технологийн болон нийтийн үйлчилгээний автомашин, тээврийн хэрэгслээр хангах, үйлчилгээ үзүүлэх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хийх, сэлбэг хэрэгслээр хангах, тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа, бэлэн байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.9 Төсөл, хөтөлбөр хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Монгол Улсын иргэний нисэхийн салбарыг Үндэсний хөгжлийн бодлого, олон улсын чиг хандлагатай уялдуулан шинэчлэн хөгжүүлэх, инновацийн болон хөгжлийн бодлогыг боловсруулах, түүнд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Дээрх чиг үүргийн хүрээнд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулах, удирдлагад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлах нэн шаардлагатай төсөл, хөтөлбөрийн төслийг боловсруулж, хэрэгжилтийг хангуулах, салбарын дунд болон урт хугацааны төсөл, хөтөлбөрийг төлөвлөн тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах, иргэний нисэхийн чиглэлээр олон улсад хэрэгжиж буй дэвшилтэт техник, технологи, инновацийг судалж нэвтрүүлэх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхд шаардагдах санхүүжилтийг гадаадын зээл, тусламж, хамтарсан төсөл, хөтөлбөр, төр-хувийн хэвшлийн түншлэл болон хуулиар зөвхөөрөгдсөн бусад эх үүсвэрээр шийдвэрлүүлэх, салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, чиглэлийн төсөл хөтөлбөрийг



боловсруулах судалгаа хийх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, холбоод зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах, иргэний нисэхийн мэдээлэл, техник технологийн системийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, оролцогч талуудын харилцан үр ашигтай, бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэх, салбарын өвөөгийн нөхцөл байдал ба хөгжлийн зүй тогтлыг тодорхойлох болон эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх өндөр технологийг нэвтрүүлэх, шинэ мэдлэг бий болгох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ИНЕГ-ын Тэргүүн дэд даргын шууд удирдлагад үйл ажиллагаа явуулах бөгөөд үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, бусад хэрэглэгчид байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд мэдээллийн технологи, инноваци, судалгаа хөгжлийн нэгж, ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх нэгж ажиллана.

### 3.3.9.1. Мэдээллийн технологи, инноваци, судалгаа хөгжлийн нэгж


Энэ нэгж нь иргэний нисэхийн салбарт мэдээллийн технологийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн салбарын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан иргэний нисэхийн салбарт дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага, боломжийг судалж, төсөл хөтөлбөрийн санал боловсруулах, Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн систем болон мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах, төлөвлөх, иргэний нисэхийн салбарт дэвшилтэт технологийг нутагшуулах, шинээр хөгжүүлэх, хүний неөцийг хөгжүүлэх, үйлдвэрлэл явуулах, зах зээлд нэвтрүүлэх, экспортпоход чиглэсэн инновацийн дэд бүтцийг бий болгох талаар бодлого боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нислэгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцан үр ашигтай, бүтээлч хамтын ажиллагааг идэвхжүүлэх замаар инновацийн соёлыг нэвтрүүлэн салбарын өрсөлдөх чадвар болон технологийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн иргэний нисэхийн салбарын тогтвортой хөгжлийн чиг хандлагыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас дэвшүүлсэн зорилтууд, олон улс, бус нутаг болон үндэсний хэмжээнд хэрэлжиж буй тсмоохон төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан тодорхойлох, нисэх буудал болон агаарын навигацийн үйлчилгээнд дэвшилтэт техник, технологи, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга хэлбэр нэвтрүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, байгууллагын хөгжлийн бодлого/зарчмыг тодорхойлж, дотоод зохион байгуулалт, неөцийг бүрдүүлэх, хуваарилах, хөгжүүлэх үйл ажиллагаанд дэвшилтэт арга, технологи нэвтрүүлэх, төлөвлөх, салбарын өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагын судалгаануудыг хийж тэдгээрийн үр дүнд үндэслэсэн дүгнэлт, зөвлөмжүүдийг боловсруулах, шинэ мэдлэг, сайн туршлагыг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.9.2 Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх нэгж

Энэ нэгж нь ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, байгаль орчин, эрүүл мэнд, онцгой байдлын салбарт бага оврын онгоц, нисдэг тэрэгний үйлчилгээг хөгжүүлэх бодлогын санал, эрх зүйн баримт бичиг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Дээрх чиг үүргийн хүрээнд иргэний агаарын тээврийн салбарт ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг удирдан зохион байгуулах, бодлого, чиглэлийг тодорхойлох, удирдлагад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллах, иргэний агаарын тээврийн салбарт ерөнхий зориулалтын нисэхийн



удирдлага, эрх зүйн орчныг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын нисэхийг аялал жуулчлал, байгаль орчин, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарт нэвтрүүлэх ажлыг дэмжин хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа агаарын навигацийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах оновчтой тогтолцоог нэвтрүүлж, салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх болон ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч ажиллана.

Сургалт, дадлагын үйл ажиллагаанд олон улсын иргэний нисэхийн байгууллага ИСАО/ын стандарт шаардлагыг бүрэн хангасан орчин үеийн сургалтын арга барил, шинэ техник мэргэжлийн боловсон хүчнийг сурган дадлагажуулах, хүний нөөцийг хөгжүүлэх бодлогод дэмжлэг үзүүлж ажиллана.

----- oCo -----

